

ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Хайлуур жонш” баяжуулах үйлдвэр “Монголжүюаньли” ХХК
Төсөл
Хэрэгжүүлэгч: Хаяг: Улаанбаатар хот, 3-р хороо, Тээвэрчдын гудамж 5 тоот

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас баруун зүгт 15 км-т байрлана.

Төсөл
Хэрэгжүүлэх
Үйлдвэрийн
Байршил:

Талбайн солбицлууд:

| | |
|--------------------|----------------|
| 1. 112° 09' 27.02” | 47° 33' 06.79” |
| 2. 112° 08' 42.02” | 47° 33' 06.79” |
| 3. 112° 08' 42.02” | 47° 33' 41.78” |
| 4. 112° 09' 27.02” | 47° 33' 41.78” |

Улсын бүртгэлийн гэрчилгээ

Улсын бүртгэлийн дугаар: 9019018095

Улсын регистрийн дугаар: 5051304

Улсад бүртгүүлсэн: 2006-03-23

“Хайлуур жонш” хайлуур жоншны ордын нөөц хүлээн авсан

Төсөл
Хэрэгжүүлэгч
Байгууллагын
Хууль эрх зүйн
Хүчинтэй
Баримтуудын
Жагсаалт:

АМГ-ын даргын тушаал,

Дугаар: №84

Он сар: 2009-04-06

ЭБМЗ-ийн дүгнэлт

Дугаар: 01-11

Он сар: 2009-03-26

ТЭЗҮ хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт

Дугаар: Т-21-04-05

Он сар: 2024-04-01

ТЭЗҮ хүлээн авсан АМГ-ын даргын тушаал

Дугаар: Т/77

Он сар: 2024-05-04

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

Дугаар: MV-010988

Олгосон: 2007-01-29

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлийн хүчинтэй хугацаа

Он сар: 2037-01-29

Хүснэгт 1. Төслийн техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

| № | Үзүүлэлт | Нэгж | Дүн |
|----------|---|---------------------------------|--------|
| 1 | Ерөнхий мэдээлэл | | |
| 1.1 | Төсөл хэрэгжүүлэгч компани | Монголжүюаньли ХХК | |
| 1.2 | Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар | 9019018095 | |
| 1.3 | Тусгай зөвшөөрлийн дугаар | MV-010988 | |
| 1.4 | Ашигт малтмалын төрөл | Хайлуур жонш | |
| 1.5 | Ордын байршил | Сүхбаатар, Түмэн-цогт | |
| 1.6 | Орд ашиглалтын хугацаа | 6 жил | |
| 2 | Геологийн хэсэг | | |
| 2.2 | Нөөцийн дүгнэлт, тушаал, дугаар огноо | 2022 - 04 - 06 Н-25 тоот | |
| 2.3 | Нийт нөөцийн хэмжээ, хүдэр | мян.тн | 762.2 |
| 2.4 | Хүдрийн дундаж агуулга | % | 37.97 |
| 25 | Эрдсийн хэмжээ | мян.тн | 289.41 |
| 3 | Технологийн хэсэг | | |
| 3.1 | Ил уурхайн ашиглалтын систем | Тэвээртэй, Гадаад овоолготой | |
| 3.2 | Ил уурхайн аргаар олборлох нөөц | мян.тн | 344.9 |
| 3.3 | Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц | мян.тн | 350.2 |
| 3.4 | Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн дундаж агуулга | % | 35.66 |
| 3.5 | Эрдсийн хэмжээ | мян.тн | 124.89 |
| 3.6 | Ил уурхайн жилийн хүчин чадал | мян.тн/жил | 100.0 |
| 3.7 | Далд уурхайн ашиглалтын систем | Хүдэр хоршоолох | |
| 3.8 | Далд уурхайн аргаар олборлох нөөц | мян.тн | 240.55 |
| 3.9 | Далд уурхайн үйлдвэрлэлийн нөөц | мян.тн | 276.98 |
| 3.10 | Далд уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн дундаж агуулга | % | 33.08 |
| 3.11 | Эрдсийн хэмжээ | мян.тн | 91.62 |
| 3.12 | Далд уурхайн жилийн хүчин чадал | мян.тн/жил | 100 |
| 4 | Баяжуулалтын хэсэг | | |


| № | Үзүүлэлт | Нэгж | Дүн |
|----------|---|--------------------|---------|
| 4.1 | Баяжуулалтын технологи | Флотаци | |
| 4.2 | Баяжуулах хүдрийн хэмжээ | мян.тн | 627.23 |
| 4.3 | Хүдрийн дундаж агуулга | % | 34.52 |
| 4.4 | Эрдсийн хэмжээ | мян.тн | 216.51 |
| 4.5 | Эрдэс авалт | % | - |
| 4.6 | Баяжмалын хэмжээ | мян.тн | 183.15 |
| 4.7 | Баяжмалын агуулга | % | 95 |
| 4.8 | Хүчин чадал | мян.тн/жил | 100 |
| 6 | Дэд бүтэц | | |
| 6.1 | Цахилгааны эх үүсвэр | Зүүн бүсийн ЦДАШ | |
| 6.2 | Нийт цахилгаан хэрэглээ /жилд/ | мян.кВт.цаг | 10,537 |
| 6.3 | Усны эх үүсвэр | Гүний худаг | |
| 6.4 | Нийт усны хэрэглээ | мян.м ³ | 366.4 |
| 7 | Эдийн засаг | | |
| 7.1 | Төслийн нийт хөрөнгө оруулалт | сая.төг | 8,232 |
| 7.2 | Ажилчдын орон тоо | | 292 |
| 7.3 | Цалингийн зардал /жилд/ | сая.төг | 7,511 |
| 7.4 | Хөдөлмөр хамгааллын зардал | сая.төг | 2,897 |
| 7.5 | Байгаль орчин нөхөн сэргээлтийн зардал | сая.төг | 1,389 |
| 7.6 | Нийт олборлолтын зардал | сая.төг | 23,077 |
| 7.7 | Нийт борлуулалтын орлого | сая.төг | 142,885 |
| 7.8 | Хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх хугацаа | жил | 1.36 |
| 7.9 | Улс орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж | сая.төг | 33,634 |
| 7.10 | Ирээдүйн мөнгөний одоогийн үнэ цэнэ NPV=10% | сая.төг | 15,747 |
| 7.11 | 1 тн жоншны баяжмалын бүрэн өөрийн өртөг | мян.төг/тн | 612.16 |

1 Ордын байршил

“Монголжүюаньли” ХХК-ийн “Хайлуур жонш” нэртэй хайлуур жоншны ордын MV-010988 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт дараах газарзүйн солбицлуудаар хязгаарлагдан оршино.

Хүснэгт 2. MV-010988 Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|--------|-----|-------|---------|-----|-------|
| | Град | Мин | Сек | Град | Мин | Сек |
| 1 | 112 | 9 | 27.02 | 47 | 33 | 6.79 |
| 2 | 112 | 8 | 42.02 | 47 | 33 | 6.79 |
| 3 | 112 | 8 | 42.02 | 47 | 33 | 41.78 |
| 4 | 112 | 9 | 27.02 | 47 | 33 | 41.78 |



Зураг 1. Ордын байршлын зураг

2 Бүс нутаг, хүн ам, эдийн засгийн мэдээлэл

Түмэнцогтын бүс нутаг нь хот суурин газраас алслагдсан учир дэд бүтэц сул хөгжсөн. Хүн амын суурьшилт сийрэг, нутгийн оршин суугчид малчид бөгөөд гол төлөв мал аж ахуй эрхэлнэ.

3 Бүс нутгийн газарзүй, уур амьсгал, ан амьтан

Газрын гадаргуугийн байдал: Газарзүйн байршлын хувьд Хэнтий нурууны зүүн хойд төгсгөлд хамаарагдана. Газрын гадарга нь тэгшивтэр, уулс нь өндөр биш 1000 -1260 м өндөртэй, уулс хоорондын хөндийнүүд өргөн. Усан хагалбар болон хөндийн ёроолын өндрийн ялгаа нь 150-250 м. Үндсэн чулуулгийн гарш дунд зэрэг, ихэвчлэн толгодын орой хяраар ажиглагддаг. Намхавтар уулсын орой, хажууд 1-1.5 м зузаантай, уулсын хормой, голын хөндийд 10 м зузаантай сэвсгэр хурдас тархсан байдаг.

Усан зүй: Ус зүйн хувьд талбай нь Номхон Далайн сав газарт харьяалагддаг. Хур тунадас бага. Талбайд хамгийн ойрхон том гол нь Хэрлэн болно. Талбайн хэмжээнд хур тунадас ихтэй жил түр зуурын урсгалтай жижиг голууд бий болдог. Хотгор нутгуудад бага хэмжээтэй урсгалгүй давс, хужиртай жижиг нуурууд олон байдаг. Нутгийн хүмүүс ихэвчлэн худгийн усыг ашигладаг.

Байгаль цаг уурын нөхцөл: Энэ газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл нь урт, зун нь богино. Хамгийн дулаан үе нь 7 сард $+19^{\circ}\text{C}$, хүйтэн нь 1 сард -26° -30°C байна. Жилийн дундаж температур нь $-2-3^{\circ}\text{C}$. Жилд унах тунадасны хэмжээ 319 мм ба үүний 80% - нь зуны үед унадаг. Цасан бүрхүүлийн зузаан бага, өвлийн улиралд хөрс нь 3 м хүртэл гүн хөлддөг. Энэ нутагт байнга хүчтэй салхилдаг бөгөөд заримдаа салхины хурд 15-25 м.сек хүрдэг.

Ургамал, амьтны аймаг: Энэ районд өндөр уулын районоос тал хээрийн бүсэд амьдардаг бүхий л амьтан бий. Төрөл бүрийн хөхтөн, жигүүртэн, хэвлээр явагч, хорхой, шавж элбэг тохиолддог.

2. ОРДЫН ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

5 Геологийн судалгааны товч түүх

“Хайлуур жонш” орд нь 1948 онд Ю.Я.Петровичийн хийсэн 1:50000-ны эрэл зураглалын ажлын үед анх илэрсэн байна. Уг талбай дээр 1972 онд Уламбаяр, Назаренко нарын удирдсан анги 75x200 м талбайд 1:5000 масштабтай эрэл зураглалын ажлыг явуулж 194 м³ суваг малталтын ажил гүйцэтгэсэн байна. Энэ ажлын үр дүнд кварц, флюоритын линз маягийн хоёр хүдрийн биетийг тогтоожээ.

1981-1984 онд хүдрийн илрэл дээр Зөвлөлтийн геологийн экспедиц 1:10000 масштабтай нарийвчилсан хайгуул болон эрэл үнэлгээний ажлыг хийсэн байна. Нарийвчилсан хайгуулын явцад 4.14 мян.м² талбайд нийт 6 суваг малтаж, 7 цооног өрөмджээ.

1984-1985 онд Зөвлөлтийн геологийн экспедицийн Бэрхийн геологийн анги нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж, 1987 онд эрэл, үнэлгээний ажлыг хийсэн бөгөөд 13 суваг малтаж нийт 17816 м³ уулын малталт хийж судалсан байна. Дээрх ажлуудаар уг орд нь хэтийн төлөв сайтай орд болох нь тогтоогдсон байна.

Уг ажлын үр дүнд “Хайлуур жонш” ордын боломжтой нөөцийг 1002.7 мян.тн, урьдчилан үнэлсэн баялгийг 252.6 мян.тн-оор тооцсон байна

6 Ордын районы геологийн тогтоц

7 Давхарга зүй

Хүдрийн талбайд дээд протерозой-доод кембри, дунд пермийн, түрүү палезой, дунд-дээд юрийн интрузив болон хожуу юра-цэрдийн дайкууд тархсан байна.

Дээд протерозой-доод кембри: Уг насны давхаргадас нь түрүү палезой ба дунд-дээд юрийн боржин дунд ксенолит маягийн биетүүд тархсан. Ксенолит нь цайвар саарал гантигжсан шохойн чулуу, бараан саарал роговикжсон аливролиитоос бүрддэг. Боржинтой хиллэсэн хэсгээрээ шохойн чулуу нь скарнжих эпидоджих хувиралд орсон байна.

Дээд перм-газрын давхаргадас: Газрын давхаргадасны эффузив чулуулаг нь талбайн баруун хэсэгт тархсан бөгөөд дунд-дээд юрийн Шар хадын комплексийн боржинд шургасан жижиг ксенолит маягийн саарал, хүрэн өнгийн липарит-дацитаас тогтсон бялхмал чулуулгаар илэрдэг.

Түрүү палезой, Хэрлэнгийн интрузив бүрдэл: Хэрлэнгийн бүрдлийн гранитууд нь илрэлийн талбайн хойд болон төв хэсгийг бүрхсэн бөгөөд 1-р фазын саарал, дунд мөхлөгт биотит-амфибол, гранодиорит, диорит 2-р фазын ягаан сараал өнгөтэй дунд мөхлөгт лейкократ биотит-амфибол, 3-р фазын жижиг ширхэгт саарал лейкократ биотит агуулсан боржингоор илэрдэг.

Дээд протерозой-доод кембрийн ксенолит боржинд агуулагдаж байгаа нь массивын эрозийн хэрчигдэл бага байгааг баталж байна.

Дунд дээд юра, Шар хадын бүрдэл: Уг бүрдлийн чулуулаг нь илрэлийн талбайн өмнө болон төв хэсгээр тархсан ба дунд том мөхлөгт шар саарал өнгөтэй липаритын хоосон зайг дүүргэсэн уулын болор болон морионы кварцтай порфир маягийн боржингоос бүрддэг. Шар хадын бүрдлийн боржингийн дайкийн бүлэг нь жижиг ширхэгт аплитийн боржин граносиенит, боржин порфиороос бүрдэнэ.

Хожуу-юра-түрүү цэрдийн дайкийн бүрдэл: Дунд хожуу юрийн боржинд нэвчсэн бараан саарал ногоон диоритын порфир, хар өнгөтэй диабаз байна. Дайкын өргөн нь 3-5 м, урт нь 100-200 м сунаж тогтсон байдаг.

Дөрөвдөгчийн хурдас: Талбайн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас нь хөндий, хоолой, жалга зэрэг нам дор хотгор газруудаар тархана. Энэ төрлийн хурдас нь улаан хүрэн өнгийн шавар, шавранцар, элс, боржингийн хэмхдэснүүдээс тогтоно.

8 Тектоник

Тусгай зөвшөөрлийн талбай нь БНМАУ-ын нутаг дэвсгэрийн тектоникийн мужлалаар төв Монголын атираат системийн блокт орших бөгөөд уг талбай нь тектоникийн хөгжлийн гурван үндсэн структурт хуваагдана.

Тус талбайн геологийн тогтоц, тектоник хөдөлгөөний горим зэрэг онцлогийг харгалзан дээд протерозой-түрүү палезой, дунд палезой-түрүү мезозой, блокийн хөдөлгөөнт гэсэн структурын комплекст ялгагдсан байна.

9 Геоморфологи

Талбай нь Ази тивийн усны хагалбарын дагуу оршдог, эх газрын эрс тэс уур амьсгалтай, геологийн хөгжлийн хувьд 2 том структурын дунд орших идэвхтэй бүсэд харьяалагддаг зэрэг онцлогоос хамаарч өөрийн гэсэн онцлогтой хөгжлийг түүлж байгаа учир геоморфологийн хувьд өөрийн зүй тогтлыг үүсгэн хөгжсөн байна. Талбай нь кайнозойн галав, неогены насны цаг үед харьцангуй тайвширч нүцгэрэл, тэгшрэлийн цаг үе эхэлсэн нь энэ нутгийн онцлог үе болж байна.

Геоморфологийн хөгжлийг дараах байдлаар ерөнхийлж ангилж болно. Үүнд:

- Тектоник – тэгшрэлийн гадарга
 - Тэгшрэл зөөгдлийн гадарга
 - Зөөгдөл хуримтлалын гадарга
1. Тектоник тэгшрэлийн гадарга нь уулын орой, нуруу хэсэгт эрчимтэй явагдаж, эндо-экзопротерозойн үйл ажиллагаа явагдаж хад, чулуу, цохио, дэл, судал нь эвдрэн бутарч, тэр хавьдаа зөөгдөөгүй хурдас хуримтлал үүсгэн, хэлбэрийн хувьд тэгширч элэгдсэн, мөлгөр гадаргуу үүсгэж байна.
 2. Тэгшрэл зөөгдлийн гадарга нь уулын хажуу, жалга, гуу даган явагдаж, нэгэнт үүссэн хурдас хуримтлалыг гравитаци, угаагдлын процесст оруулан үргэлжийн тайван байдлыг алдагдуулан зөөж байгаа хэсэг юм. Тухайн районд энэ үйл явц маш идэвхтэй явагдаж, түр зуурын урсгал, шилжилт эрчимжиж ялангуяа уулын бэл хормой зузаарч, тухайн үедээ хурц оройтой уул, нуруу нь харьцангуй тэгширч байна. Хурдасны гарал үүсэл нь делюви, пролюви, элюви процесс давамгайлж байгаа боловч нуурын ба транс-элюви /зөөгдөл/-ийн үйл ажиллагаа тухайн районд шууд үйлчилж байна.
 3. Судалгааны талбайн ойролцоо нэвт гарсан гол мөрний ай савгүй зөвхөн орон нутгийн үйл ажиллагаатай булаг, шанд, нуур, тойром байдаг учир хуримтлалын үйл

ажиллагаа маш өвөрмөц явагддаг байна. Өөрөөр хэлбэл элэгдлийн үйл ажиллагаагаар үүссэн геологийн процесс нь богино зайд эрчимтэй явагддаг тул хуримтлалын үйл ажиллагаа эрчимтэй болдог байна.

Эдгээр нь цаг ууртай холбоотой болохоор том хөндий, нуур тойрмууд даган бүх үйл явдал болдог тул богино зайд тухайн хэсэгтээ бие даасан бусдаасаа ялгаатай геоморфологийн хөгжил явагдсаар иржээ. Ийм гадаргуугийн хэмжээнд Талын шарын хөндий, Хэрлэн голын хөндий зэрэг битүү хөгжилтэй хотгор газрууд үүсжээ.

10 Гидрогеологи

Түмэнцогтын хүдрийн районд гидрогеологийн судалгаа төдийлөн сайн хийгдээгүй. Геологи хайгуулын ажлын материалаас харахад уг районд тархсан гүний, бялхмал, хувирмал чулуулагт ан цавын, доод цэрд, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд нүх сүвний ус тархжээ.

Дөрөвдөгчийн хурдасны уст үе /Q_{IV}/: Дөрөвдөгчийн хурдасны уст үе хуурай сайруудын дагуу түүнчлэн жижиг нуурын хотгоруудад үүссэн пролюв, аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан байна. Ус агуулагч чулуулаг нь хайр, хайрга, дайрга, шавранцар, элсэнцэр болно. Хуурай сайрын дагуу тархсан пролювийн хурдасны зузаан нь 1-3 м, уст үеийн зузаан нь 2 м хүрдэг. Энд муу мөлгөржсөн хэмхдсэн хурдас зонхилно.

Аллюв-пролюв, нуурын хурдсанд шаврын материалын хэмжээ өсч, хэмхдэсний хэмжээ жижгэрч салаавчилсан үеүдийг үүсгэнэ. Зузаан нь 10-30 см. Уг уст үеийн усжилт харилцан адилгүй шаварлаг материалын агуулгаас ихээхэн хамаардаг.

Ерөнхийдөө сул усжилттай. Хурдсуудын ундарга нь 0.5 л/с хүрдэг. Аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан ус нь газрын доорх усны хөдөлгөөний тогтонги нөхцөлд оршдогоос сул давстай байдаг байна. Пролувийн хурдасны ус нь химийн найрлагын хувьд сайн, эрдэсжилт бага байна.

Энэ нь тэжээгдлийн сайн нөхцөлд оршдогоороо тайлбарлагдана. Дөрөвдөгчийн уст үе газрын гадаргууд ойр оршдог тул /0.5-0.3 м/ усаа ууршилтаар ихээр алдаж, бага хэмжээгээр гипсометрийн хувьд дор байрлах бусад уст үе, давхаргуудад алддаг байна. Ууршилтад ихээр өртөх нь усны химийн найрлагад эрдэсжилт ихсэхэд нөлөөлдөг.

Уг уст үе давхаргын усны химийн найрлага нь сульфатлаг, сульфат-хлорлог, хлорлог кальци-натрийн, натрийн найрлагатай. Эрдэсжилт нь 0.8-1.5 г/л, хааяа 2 г/л түүнээс дээш байдаг.

Доод цэрдийн зүүн баянгийн давхаргадасны уст давхарга: Доод цэрдийн Зүүнбаянгийн давхаргадасны хурдас нь судалгааны талбайн зүүн хэсэгт Талын шандын хөндийд тархжээ. Ус агуулагч чулуулаг нь сул барьцалдсан хөрзөн чулуу, алевролит, элсэн чулуу юм. Хөрсний усны тогтонги түвшин 0.5-7.5 м-т байрлана. Чөлөөт гадаргуутай. Доод цэрдийн хурдсанд агуулагдаж байгаа усны найрлага нь ихэвчлэн холимог, цэнгэг ба сул давслаг. Уг уст давхарга нь агаарын хур тунадсаар тэжээгддэг. Усаа гипсометрийн доор байрлах уст давхаргуудад алдана. Энэ уст давхаргын эрдэсжилт, усны найрлагын талаарх мэдээлэл байдаггүй. Дээрх уст давхаргуудын усыг нутгийн ардууд унд болон ахуйн хэрэгцээндээ өргөн хэрэглэдэг.

11 Ашигт малтмал

Түмэнцогтын хүдрийн зангилаанд “Хайлуур жонш” ордоос гадна хайлуур жоншны 2 орд, 7-н илрэл, 95 эрдэсэжсэн цэг, фторын шинж тэмдэг өгсөн 60 хэсэг газар байдаг байна.

12 Ордын геологийн тодорхойлолт

13 Ордын хүдэржилт, хүдрийн биетийн тогтоц

Ерөнхий хүдэржилт нь Зос голын хагарлын нөлөө болон түүнээс салбарласан тектоник хагарлууд ба ксенолит гантигжсан шохойн чулууны холбоотой. Зөв биш хэлбэртэй хайлуур жоншны хүдрийн биетүүд нь гидротермаль-метасоматит гаралтай. Хүдрийн биетүүд нь суналын болон уналын дагуу ширгэж алга болдог.

Хүдрийн биетүүд нь Шархадын гранитойдын бүрдэл девоны гантигжсан шохойн чулууны тектоникийн хилийг дагаж үүссэн байна. Биетүүд нь боржинд энгийн шугаман хэлбэртэй байдаг бол шохойн чулуунд тодорхой бус урссан маягийн контуртай тогтсон байдаг. Уг орд дээр хэмжээ болон морфологийн онцлогоороо ялгаатай 5 хүдрийн биет тогтоогдсон байна.

Хүдрийн биет-1

1-р биет нь ордын төв хэсэгт уртрагийн дагуу сунаж тогтсон зөв биш мэшил хэлбэртэй юм. Хамгийн өргөн хэсэг нь биетийн баруун талаар боржин шохойн чулууны заагаар хиллэсэн контактын орчимд, хамгийн нарийн хэсэг нь хүдрийн биетийн зүүн талд порфирын төрлийн биотиттой боржинтой хиллэсэн хэсэгт ажиглагддаг. Хоёр талаараа зүүн хойшоо чиглэлтэй хагарлуудаар хязгаарлагдсан.

Хүдрийн эрдэсжилтийн бүрэлдэхүүнд кварц, хайлуур жонш, багаар каолинит, кальцит, бал чулуу болон бусад эрдсийн хольц орно. Хайлуур жонш нь бага зэрэг талсажсан, цагаан, цайвар ягаан, саарал, ногоондуу өнгөтэй байна.

Хүдэр нь нягт, брекч маягийн, толботой заримдаа судлархаг текстуртай. Хүдэр орчмын өөрчлөлт нь боржингийн каолинжилт болон шохойн чулууны цахиуржилтаар илэрдэг. Хүдрийн биетийн урт нь баруунаас зүүн тийш 300 м сунаж тогтсон, өргөн нь 10 м, эгц хойшоо 45-75 хэмийн уналтай, фторт кальцийн агуулга нь 2.7-81.8 % байна.

Хүдрийн биет-2

1-р хүдрийн биетээс хойно байрлах ба түүнтэй параллель тогтоцтой. Кварц хайлуур жоншны хүдэржилт нь тектоникийн суларсан бүсийн дагуу судал маягийн хэлбэртэй суналын дагуу 110 м үргэлжилдэг.

Биетийн зузаан нь тогтвортой биш. Уналын өнцөг нь эгц хойшоо 75-80 хэм байна. Фторт кальцийн агуулга нь 24.91-51.82 % байдаг. Хүдэр нь цул текстуртай, талст структуртай өнгө нь ногоон, ягаавтар, өнгөгүй байна.

Хүдрийн биет-3

Хүдрийн 3-р биет нь талбайн урд талд ксенолит ба гантигжсан шохойн чулууны бүсэд байрлалтай байна. Хажуугийн чулуулаг нь аргиллитжсан, лимонитжсон зарим интервал нь бал чулууны дагуу байдаг.

Биетийн өргөн нь 12-32 м, урт нь 120 м. Баруунаас зүүн тийш суналтай, Уналын өнцөг нь 45-55 хэм байна. Флюоритийн өнгө нь ягаан, цайвар ягаан, саарал байна. Фторт кальцийн агуулга нь 35-75 % хүрдэг байна.

Хүдрийн биет-5

Ордын зүүн хэсэгт 1-р хүдрийн биетийн урд байрладаг. Баруун хэсгийг 205-р сувгаар, зүүн хэсгийг нь 206-р сувгаар нээсэн байна. Сунал нь уртрагийн дагуу бөгөөд 8-р хайгуулын шугамын ойролцоо зүүн урагшаа чиглэсэн байна

Уналын өнцөг нь эгц 70-80 хэм. 5-р хүдрийн биет нь нарийн судлын төрлийн биет бөгөөд талстлаг структуртэй, флюорит нь ягаан, ягаавтар, ногоон өнгөтэй байна.

14 Ордын үнэлгээ

“Хайлуур жонш” ордын хүдрийн биетүүд нь гидротермаль-метасоматит гаралтайгаас гадна суналын болон уналын дагуу хурдан ширгэж алга болдог. Хүдрийн биетүүд нь Шархадын гранитойдын бүрдэл, Девоны гантигжсан шохойн чулууны тектоникийн хилийг дагаж үүссэн байна. Ордын хэмжээнд үндсэндээ 3 хүдрийн бүсийг тогтоожээ.

Үүнд: Хойд хүдрийн бүс

Баруун хүдрийн бүс

Өмнөд хүдрийн бүс багтана.

Баруун хүдрийн бүс нь талбайн баруун захад нарийн эффузив чулуулаг, орчин үеийн хурдсын зааг орчимд баруун хойш чиглэсэн гүний хагарлуудын салбар ан цавуудаар үүссэн байна. Энд ерөнхийдөө баруун хойш 305-310 градус чиглэлтэй 5 биет ялгагдсан байна.

Хүдрийн биетүүд нь кварц-хайлуур жонш, кварц-карбонат-хайлуур жонш гэсэн хоёр төрлийн хүдрээс бүрддэг. Эдгээр нь хүдрийн найрлага, агуулга, структур, текстурын онцлогоороо өөр хоорондоо ялгаатай.

Кварц-хайлуур жоншны хүдрийн биет: Ордын хэмжээнд бага хувийг эзлэх бөгөөд жоншны агуулга нь 45%-иас ихгүй, кварц нь хальцедон маягийн, жижиг ширхэгтэй, хайлуур жонш нь дундаас том ширхэгтэй, ихэвчлэн жижиг ширхэгт судал, хаяа үүр маягаар агуулагдсан байх ба цайвар ягаан, ягаан, цайвар ногоон өнгөтэй байдаг.

Кварц-карбонат-хайлуур жоншны хүдрийн биет: Ордын ихэнх талбайг эзэлдэг. Хайлуур жоншны агуулга 25-60% хүрдэг. Хүдэр нь жижиг ширхэгтэй, ягаан, цайвар ногоон, саарал өнгөтэй хайлуур жонш болон хөх саарал, хар хөх өнгийн кварцаас тогтдог. Бутралд орсон кварц-хайлуур жонш харавтар, хар саарал, бор ногоон өнгийн хальцедон маягийн кварцын хэмхдэс каолиноор цементлэгдсэн маягаар тогтсон байдаг.

Хайлуур жоншны талбайд одоогоор хайлуур жоншны илрэлээс өөр сонирхол татахуйц ашигт малтмалын ямар нэгэн төрөл тогтоогдоогүй байна.

Тектоникийн хагарал орчим ба девоны шохойлог зузаалаг, үе палезойн боржингийн хил заагаар роговикжилтийн сулавтар хувирлууд байгаа боловч өмнөх судлаачдын дүгнэснээр литогеохимийн

сорьцлолтын сорьцын гэрлийн шинжилгээгээр ямар нэгэн элементийн өндөр агуулга тогтоогдоогүй, ихэнхдээ орон нутгийн фон агуулгын түвшинд тодорхойлогдсон байна.

“Хайлуур жонш” орд дээр нийтдээ 31 цооног өрөмдөж, 20 гаруй мянган метр куб суваг малталтын ажил хийж судалгаа хийсэн байна.

15 Ордын уул-техникийн нөхцөл, чулуулгийн шинж чанар

Хайлуур жоншны орд Хүдрийн биетүүдийн байршил гадаргуугийн талаасаа ил аргаар ашиглалт явуулахад тохиромжтой. Хүдрийн биетүүд ба агуулагч чулуулаг нь 2 м гүн хүртэл өгөршилд нэлээд автсан ба ан цавархаг шинжтэй. Чулуулаг тогтворжилт сайтай бөгөөд зарим хэсгүүдэд цавшсан ба үешиж суларсан 0.5-3.0 м зузаантай бүсүүд тохиолдоно. Эдгээр чулуулаг нь VI зэрэглэлийн хатуулгаас хэтрэхгүй бат бэхийн үзүүлэлттэй. Орд нь усны шүүрэлт багатай ба хөрсний үс нь 0.5-7.5 м гүнд хэлбэлздэг. Орд газарт ой мод, урсгал ус, намаггүй учраас уул техникийн таатай нөхцөлд оршдог гэж үздэг. Хүдрийн найрлага, технологийн шинж чанар

16 Хүдрийн биетүүдийн эрдэслэг бүрэлдэхүүн

Хүдрийн биетүүдээс авсан дээжүүдэд хийсэн химийн шинжилгээгээр CaF_2 -ын агуулга 20-85 %, SiO_2 -ын агуулга 15-75 %, CaCO_3 -ийн агуулга 0.6-30 % хүрдэг байна. Хүхрийн агуулга 0.0001-0.005 %, харин фосфорын агуулга 0.01-0.1 %-иас хэтэрдэггүй.

Эрэл, эрэл үнэлгээний ажлын үед хүдрийн бодисын найрлага, хүдэр баяжуулах технологи баяжмалын төрлийг ялгах зорилгоор хүдрийн биетээс технологийн сорьц авч лабораторид технологийн судалгаа хийлгүүлсэн байна.

Технологийн дээжлэлт

1. Бөөний болон гравитацийн баяжмалын гарцыг тодорхойлох
2. Хайлуур жоншийг ялгаж авах болон баяжуулалтын аргыг сонгох
3. Хүдрийн биетийн хэлбэр, хүдрийн ашигтай ба хортой хольцыг тогтоох

хүдрийн бодисын найрлагыг тогтоох зорилгоор авдаг.

17 Технологийн шинж чанар

Хайлуур жоншны хэмхдэсний хэмжээ болон агуулгаас хамааруулан баян ба ядуу агуулгатай гэж 2 хуваадаг.

Ядуу агуулгатай хүдэр нь флотацийн баяжмал гаргаж авахад ашигтай. Фторт кальцийг 25-53% агуулсан хүдэр байна. Карбонат-кварц-хайлуур жоншны хүдэрт CaF_2 29% - 50% кальцитынх 7-30% хүрдэг. Ийм хүдэр баяжуулахад хүнд байдаг.

“Хайлуур жонш” ордын хүдэр нь энэ төрөлд багтдаг. Баян хүдэрт CaF_2 -ын агуулга нь 55-65% байдаг. Ийм хүдрээс гравитацийн болон бөөний баяжмал гарган авахад хамгийн ашигтай.

Гар аргаар хүдэр олборлоход 75% хайлуур жоншны агуулгатай 10% гарцтай 15% ялгаралтай. ФК-75 маркийн баяжмал ялган авах боломжтой.

18 Ордын геологийн нөөцийн тооцоо

“Хайлуур жонш” нэртэй ордын 1, 2, 3-р хүдрийн биетүүд нь юрийн настай Шархадын гранитоидын бүрдэл, девоны настай гантигжсан шохойн чулуу хоёрын хил заагаар тектоникийн хагарал, эвдрэлийг дагаж үүссэн гидротермаль-метасоматит гаралтай мэшил (линз) маягийн маш

хурдан суналын болон уналын дагуу огцом шургаж, ширгэн алга болдог. Ийм байршил, хэлбэр хэмжээтэй хүдрийн биетүүдээс тогтсон ордыг дээд дурдсан III бүлгийн ордод хамааруулсан байна.

Хайлуур жонш” нэртэй ордын 1, 2, 3, 5-р хүдрийн биетүүдэд 1981-1987, 2008, 2019 онуудад гүйцэтгэсэн эрэл, эрэл-үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажил болон нөөцийг дахин тооцож үнэлсэн тайлангийн үр дүнг нэгтгэн боловсруулж, хайлуур жоншны бодитой В зэрэг, боломжтой С зэргийн нөөцийг дахин шалган тооцож, геологийн блокийн аргаар нөөцийг бодсон байна. Нөөцийг давхар шалгах зорилгоор Geova Surpac программ дээр гурван хэмжээст хүдрийн биет үүсгэж эзлэхүүн тооцсон байна.

Хүснэгт 3. “Хайлуур жоншны” ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

| № | Хүдрийн биетийн дугаар | Блокийн дугаар | Талбай, м ² | Дундаж зузаан, м | Эзлэхүүн, м ³ | Нягт, т/м ³ | Хүдрийн хэмжээ, тн | Дундаж агуулга, % | Эрдсийн нөөц, тн |
|------|------------------------|----------------|------------------------|------------------|--------------------------|------------------------|--------------------|-------------------|------------------|
| 1 | 1 | 1-1В | 6,419 | 5.51 | 35,369 | 2.6 | 91,959.0 | 29.41 | 27,045.15 |
| 2 | | 1-2В | 5,225 | 7.93 | 41,433 | 2.6 | 107,727.0 | 36.74 | 39,579.90 |
| 3 | | 1-3В | 5,353 | 4.28 | 22,910 | 2.6 | 59,565.7 | 39.36 | 23,445.68 |
| 4 | | 1-4В | 7,092 | 2.24 | 15,887 | 2.6 | 41,306.4 | 38.04 | 15,713.97 |
| 5 | | 1-5В | 7,658 | 2.53 | 19,375 | 2.6 | 50,376.6 | 41.11 | 20,709.40 |
| 6 | | Дүн | 31,747 | 4.25 | 134,974 | 2.6 | 350,933.8 | 36.04 | 126,491.09 |
| 7 | | 1-1С | 5,686 | 4.24 | 24,110 | 2.6 | 62,686.0 | 37.69 | 23,626.35 |
| 8 | | 1-2С | 9,212 | 3.23 | 29,755 | 2.6 | 77,362.9 | 38.98 | 30,156.66 |
| 9 | | 1-3С | 22,274 | 1.9 | 42,321 | 2.6 | 110,034.3 | 37.31 | 41,054.80 |
| 10 | | 1-4С | 8,559 | 0.8 | 6,847 | 2.6 | 17,802.2 | 40.42 | 7,196.65 |
| 11 | | Дүн | 45,731 | 2.25 | 103,032 | 2.6 | 267,884.4 | 38.09 | 102,031.45 |
| Нийт | | | 77,478 | 3.25 | 238,007 | 2.6 | 618,817.1 | 36.93 | 228,523.55 |
| 12 | 2 | 2-1С | 1,851 | 3.34 | 6,181 | 2.6 | 16,071.7 | 49.85 | 8,011.24 |
| 13 | | 2-2С | 1,334 | 7.96 | 10,617 | 2.6 | 27,603.1 | 44.38 | 12,250.27 |

| | | | | | | | | | |
|----|------|------|---------|------|---------|-----|-----------|-------|------------|
| 14 | | 2-3С | 1,518 | 5.54 | 8,408 | 2.6 | 21,861.6 | 38.02 | 8,311.38 |
| 15 | | Дүн | 4,702 | 5.61 | 25,206 | 2.6 | 65,534.4 | 43.6 | 28,573.90 |
| 16 | 3 | 3-1С | 994 | 2.11 | 2,097 | 2.6 | 5,452.5 | 33.65 | 1,834.41 |
| 17 | 5 | 5-1С | 7,176 | 1.84 | 13,203 | 2.6 | 34,328.1 | 46.77 | 16,055.26 |
| 18 | | 5-2С | 6,405 | 0.86 | 5,509 | 2.6 | 14,323.6 | 41.39 | 5,928.12 |
| 19 | | 5-3С | 6,817 | 1.34 | 9,134 | 2.6 | 23,750.5 | 35.8 | 8,502.34 |
| 20 | | Дүн | 20,398 | 1.35 | 27,846 | 2.6 | 72,400.3 | 42.11 | 30,486.72 |
| 21 | НИЙТ | | 103,572 | | 293,155 | 2.6 | 762,203.2 | 37.97 | 289,416.59 |

3. УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ТЕХНОЛОГИ

Уурхайн одоогийн байдал

Хайлуур жоншны орд нь 2007 оноос эхлэн олборлолт болон жоншны хүдэр баяжуулах үйл ажиллагаа явуулж ирсэн байна. 2007 оноос 2019 он хүртэл ил уурхайн аргаар 190.2 мян.тн хүдэр олборлон баяжуулж, 573 мян.м³ хөрс хуулалтын ажил хийсэн байна. 2017 оноос далд уурхайн үндсэн болон бэлтгэл малталтаар нийт 828 м нэвтэрч, 32.1 мян.тн хүдэр олборлосон байна.

20 2024 онд Ил уурхай

Уурхай нь хоногийн 2 ээлжээр ажилладаг ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байдаг. Ажилчид 20 хоног уурхай дээр ажиллан 10 хоног амрах горимоор ажилладаг.

Тайлбар: Тус уурхай нь 2019 он хүртэл дээрх ээлжээр ажиллаж байсан ба уг төсөлд 2024 оны 01-р сарын 01 -эс хэрэгжиж эхэлсэн “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар ээлжийн ажил нь 14/14 хоног байхаар тусгасан болно.

21 2024 онд Ашиглалтын систем

Хайлуур жоншны ил уурхайд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем, далд уурхайд хүдэр хоршоолох ашиглалтын системээр ажилладаг.

Хүснэгт 4. Ил болон далд уурхайн ашиглалтын технологийн схем

| Ашиглалтын арга | Ашиглалтын систем | Үндсэн ажил | Технологийн процессууд |
|-----------------|------------------------------|---------------------------------------|------------------------|
| Ил уурхай | Тээвэртэй, гадаад овоолготой | Хөрс хуулалт | Өрөмдлөг тэсэлгээ |
| | | | Ухаж ачих |
| | | | Тээвэрлэх |
| | | | Овоолох |
| | | Хүдэр олборлолт | Ухаж ачих |
| | | | Тээвэрлэх |
| Овоолох | | | |
| Далд уурхай | Хүдэр хоршоолох | Үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлт | Өрөмдлөг тэсэлгээ |
| | | | Ухаж ачих |
| | | | Тээвэрлэх |
| | | | Овоолох |
| | | Хүдэр олборлолт | Ухаж ачих |
| | | | Тээвэрлэх |
| Овоолох | | | |



Зураг 2. Уурхайн одоогийн байдал



Зураг 3. Уурхайн одоогийн байдал

22 Уурхайн үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмж

Ил уурхайн хөрсний чулуулагт өрөмдлөг тэсэлгээний аргаар чулуулгийг ухаж ачихад бэлтгэж байна. Нийт ашиглалтын хугацаанд 573.6 мян.м³ уулын цул тэсэлсэн байна.

Ил уурхайд уулын ажилд 1 ш Hyundai R380LC-9 экскаватор, 3 ш Howo автосамосвал, 1 ш Luigong ZL50CN утгуурт ачигч, 1 ш Shantui SD16 бульдозер тус тус ажиллаж байна.

Ил уурхайгаас гарах хөрсний чулуулгийг уурхайн урд талд байрлах хөрсний гадаад овоолгод хураадаг. Хөрсний гадаад овоолго нь одоогоор 16-22 м өндөр, 7.3 га, 573.6 мян.м³ орчим багтаамжтай байна.



Зураг 4. Хөрсний овоолго

Хүснэгт 5. Ил уурхайн тоног төхөөрөмж

| Техник | Марк | Үзүүлэлт | Тоо | Үлдэгдэл үнэ, сая.төг |
|---------------|------------------|--------------------|-----|-----------------------|
| Экскаватор | HYUNDAI R380LC-9 | 2.1 м ³ | 1 | 405 |
| Автосамосвал | HOWO ZZ3257 | 30 т | 3 | 180 |
| Бульдозер | Shantui SD16 | 169 кВт | 1 | 160 |
| Утгуурт ачигч | Luigong ZL50CN | 3 м ³ | 1 | 75 |



Зураг 5. Hyundai R380LC-9 экскаватор



Зураг 6. Nowo автосамосвал



Зураг 7. Shantui SD16 бульдозер

Өнгөрсөн хугацаанд явуулсан уулын ажлаас харахад техник, технологи, ашиглалтын систем, ашиглагдаж буй тоног төхөөрөмж зэрэг нь уурхайн аюулгүй ажиллагаа, уулын ажилд ямар нэг хүндрэл үзүүлээгүй байна. Цаашид уулын ажил явуулахад одоогийн ашиглагдаж буй технологийн схем, тоног төхөөрөмжийг үргэлжлүүлэн ашиглах боломжтой юм.

Далд уурхайд ашиглаж байсан тоног төхөөрөмжүүд нь элэгдэж, эвдэрч дууссан бөгөөд уг төсөлд далд уурхайн тоног төхөөрөмжийг шинээр авахаар тусгасан болно.


23 Дэд бүтэц

Хайлуур жоншны ордын төслийн бүтээн байгуулалтын ажил 2007 оноос эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар ордын талбайд уурхайн үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай дараах объектууд байгуулан ашиглаж байна. Үүнд:

- Ажиллах хүчний орон сууц, кэмп
- Цахилгаан хангамж
- Захиргаа
- Тэсрэх материалын агуулах
- Ундны болох үйлдвэрлэлийн усан хангамж, гүний худгууд
- Засварын газар
- Баяжуулах үйлдвэр
- Химийн бодисын агуулах
- Хаягдлын аж ахуй
- Уурын зуух
- Бусад инженерингийн байгууламжууд байгуулсан байна.

24 Цахилгаан хангамж

Ордын цахилгаан хангамжийг Түмэнцогт сумаас 15 км зайд 35 кВ-ийн ЦДАШ татсан. Ордын талбай дээр 35/0.4 кВ-ын дэд станц байгуулсан. Цахилгаан тасарсан үед уурхайн онцгой чухал хэсгүүдийг хангахад зориулж, ашиглахаар АД-100 маркийн дизель станц 1 ширхгийг байрлуулсан байна.



Зураг 8. Цахилгаан хангамжийн тойм схем

Байгаль хамгаалах төлөвлөгөөний агуулга

Төслийн хэрэгжүүлэх үе шат бүрт гарах гол болон сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах, нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга зам, зөвлөмж зэргийг багтаасан болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулсан аргачлал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамруулан авч үзлээ. Энэхүү төлөвлөгөө нь хайлуур жонш олборлох үйл ажиллагаа явуулах хугацаанд хүчин төгөлдөр байна.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-уудыг, Байгаль орчны Сайдын тушаалаар баталсан “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачилсан заавар”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ” зэргийг удирдлага болгон ажилладаг.

ХОЁР: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

Хөрс

Өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, хүдэр олборлох, тээвэрлэх, ангилан ялгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдохоос гадна шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Уурхайд ажиллагсад, ойр орчинд байгаа хүн, мал, бичил амьтан, ургамал амьтан зэрэг нь нөлөөлөлд өртөх объект болно. Байгаль орчинд бохирдол үүссэн тохиолдолд бохирдол нь ургамал, хөрсөөр дамжин хүрээгээ тэлэх магадлалтай. Эвдэрсэн газар, хөрсийг стандарт MNS 5917:2008-ын дагуу нөхөн сэргээнэ. Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материал ил задгай асгахыг хориглоно. (БОЯ, ЭХЯ-ны сайдын 1989.06.22-ны 68/А/61 дугаарын тушаал). Газар ашиглалтын бүртгэл мэдээг хөтөлж, холбогдох байгууллагад орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд тайлагнана.

Агаар орчны бохирдол:

Хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас элдэв гаж үнэр гарах, тоосжилт, утаа тортог, CO, SO₂, NO₂-ын хэмжээ ихэсч болзошгүй. Агаарын бохирдол нь ордод ажиллагсад, ойр орчимд буй хүн, мал, амьтан, ус, ургамал, хөрсөнд нөлөөлж болзошгүй. Эрүүл ахуйн хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг” (Улсын ариун цэврийн байцаагчийн 1989 оны 11 тоот тушаалын 2-р хавсралтаар) баримтална.

Усны бохирдол:

Далд уурхайн ашиглалтын түвшинд гүний ус илрээгүй бөгөөд уурхайн болон баяжуулах үйлдвэрийн технологийн болон ундны усны хэрэгцээг хангах зорилгоор 3 ширхэг гүний худаг гаргасан ба худгийн паспортыг хавсаргав. Үйлдвэрийн хаягдал ус хаягдал усны даланд хуримтлагдах ба гүний болон гадаргын усанд сөрөг нөлөөгүй.

